

**Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн**

**анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь**

... оны ... -р сарын ...-ны өдөр  
Сайншад сум

**Нэхэмжлэгч: Боржигон овогт ...../А/.....-ийн ...../Б/.....нэр Дорноговь аймаг, Мандах сумын ...баг.... байр.....тоот Утас:xxxxxxx**

**Хариуцагч:Дорноговь аймгийн Хатанбулаг сум,... баг “000” ХХКомпани  
Захирал: .../П/.... , Утас: xxxxxx Шинэ хаягийг заавал бичих**

**Нэхэмжлэлийн шаардлага: Гэрээний үүрэг хангуулах тухай**

**Нэхэмжлэлийн үндэслэл:**А.Б би “000” ХХК-тай ... оны ... дугаар сарын ....-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан Их Монгол 800 жилийн ойд зориулан 108 морин хуурыг нэг бүрийг нь 30.000 төгрөгөөр тооцож ... оны ... сарын ...-ны өдрийн дотор хийж хүлээлгэн өгөхөөр тохиролцсон. Гэрээний дагуу урьдчилгаа хөлс 1620000 төгрөгийг гэрээ байгуулж гарын үсэг зурсаны дараа хүлээн авсан.Би гэрээнд заасны дагуу морин хуурыг хийх материалыг захиалагч талд үзүүлж нэг хуур хийж үзүүлэхэд захиалагч тал зөвшөөрч эх загварыг сонгож байгаагаа мэдэгдэж гарын үсэг зурсан. Үүний дагуу би 108 морин хуурыг хугацаанд нь хийж гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгсөн.“000” ХХКомпани нь одоогоор ажлын хөлсний үлдэгдэл болон 1620000 төгрөгийг өгөх боломжгүй байгаа тул танд 7 хоногийн дараа өгье гэхэд нь би зөвшөөрсөн боловч өнөөг хүртэл өгөөгүй байгаа.Иймд гэрээнд заасны дагуу төлбөрийг бүрэн төлөхийг шаардсан боловч “тантай гэрээ байгуулсан хүн ажилаасаа халагдсан тул бид мэдэхгүй байна” гээд одоо болтол хөлсийг минь өгөхгүй байгаа тул “000” ХХ Компаниас гэрээний үүргийн биелэлтийг хангуулж 1620000 төгрөгийг гаргуулж өгнө үү.

**Нэхэмжлэл гаргасан. / Гарын үсэг / А.Б**

**Нэхэмжлэлд хавсаргасан баримт бичиг**

1. Нэхэмжлэл 2 хувь
2. “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний 1 хувь
3. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт-1 хуудас
4. Урьдчилгаа төлбөр хүлээн авсан баримтын хуулбар -1 хувь
5. Морин хуур хийхэд зарцуулсан бараа материалын тооцооны хуудас- 1 хуудас
6. Гэрээний дагуу 108 морин хуур хүлээлцсэн акт- 1 хувь
7. Нийт ... хуудас материал хавсаргав

Улсын тэмдэгтийн хураамж төлөхдөө шүүхэд хандах болон Дорноговь аймгийн Татварын газарт хандан төлбөрийн даалгавар үүсгүүлж хураамжаа банкинд тушаана.

**Шүүхийн утас: 70522144, 92172020**

**Анхаарах:/Та цаасны зүүн захаас 30 мм, дээд, доод захаас 20мм, баруун захаас 15 мм зайтай бичнэ/**

**/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг**

**гаргаж өгнө/**